



**ЦЭВЭР УСААР ХАНГАХ,
ХЭРЭГЛЭЭНЭЭС ГАРСАН БОХИР
УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ**

**МАНДАЛГОВЬ ХОТ
2019 ОН**

Батлав

“Дундговь-Ус” ОНӨҮГ-ын захирал



Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ

2023 оны 5 сарын 15 өдөр. №

Монгол улсын Иргэний хууль, Хот сууринь усан хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, Ус ашиглалтын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үндэслэн нэг талаас Дундговь-Ус ОНӨҮГ-ыг төлөөлж

Н.Г-бо ажилтай Очир овогтой Соригын /цаашид хангагч гэх/ нөгөө талаас ГХБХБГ

ийг төлөөлж Зарла ажилтай Э.Чалмаагэрэл нар/ цаашид хэрэглэгч гэх/ цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулахтай холбогдон гарах харилцааг зохицуулахаар тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээг 2023 оны 5..... сарын 15 ний өдөр байгуулж нэг жилийн хугацаатай мөрдөх бөгөөд гэрээний хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө хэрэглэгч, гэрээг сунгах тухай хүсэлтээ хангагч байгууллагад тавьж нэг жилийн хугацаагаар сунгаж өмнөх гэрээг дүгнэн, хоёр талын төлөөлөл тэмдэглэл хийж сунгалт хийнэ.

1.2. Хэрэв хэрэглэгч албан ёсоор хүсэлтээ гаргаагүй бол гэрээний хугацаа дахин нэг жилээр сунгагдсан гэж үзэж цаашдын харилцаа гэрээний дагуу зохицуулагдана.

1.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахтай холбогдсон харилцааг иргэний хуулийн дагуу зохицуулна.

Хоёр. Хангагчийн эрх, үүрэг

2.1. Хангагч нь энэхүү гэрээний 1.1-д заасан хууль дүрмүүд болон бусад холбогдох хууль эрхийн актуудад заагдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2.2. Хангагч нь “Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын хууль”-ийн 6-р зүйлд заасан техникийн нөхцөл хангасан хэрэглэгчтэй гэрээ байгуулна.

2.3. Хангагч нь хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангаж, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулна.

2.4. Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжинд төлөвлөгөөт засвар хийх болон эвдрэл гэмтлийн улмаас хэрэглэгчийг усаар хангах боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд хангагч хэрэглэгчид хязгаарлалтын хугацааг 4-өөс доошгүй цагийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

2.5. Усан хангамж, бохир ус татан зайлуулахтай холбогдон гарах хэрэглэгчийн санал, гомдлыг тухай бүр хүлээн авч барагдуулна.

2.6. Усаар хангах, бохир ус татан зайлуулах үйл ажиллагаанд хангагчийн буруугаас хэрэглэгчид хохирсон тохиолдолд хангагч хохирлыг шууд хариуцна.

2.7. Хангагч дараахи нөхцөлд усны хэрэглээг хангагчид урьдчилан мэдэгдэхгүйгээр зөрчлийг арилгах хүртэл хязгаарлалт хийнэ. Үүнд:

2.7.1. Хэрэглэсэн бүтээгдэхүүний төлбөрөө 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй, хуримтлагдсан өртэй.

2.7.2. Хангагчийн зөвшөөрөлгүй өөрийн хэрэглээнээсөөр хэрэглэгчийг дур мэдэн холболт хийсэн.

2.7.3. Хэрэглэгч усны тоолуурыг санаатайгаар зогсоосон, лацыг тасалсан, тоолуурын гаднаас тойруулж холболт хийсэн, эд анги битүүмжлэлийг өөрчилсөн.

2.7.4. Хэрэглэгч өөрийн байранд нэвтрэн орж үзлэг хийх боломжийг хангагчийн эрх бүхий ажилтанд олгоогүй

2.7.5. Хэрэглэгчийн гадна шугамын анхны худгаас барилга доторхи тоолуур хүртлэхи шугаманд усны алдагдал гарсан

2.7.6. Усан хангамжийн эх үүсвэрийн байгууламжинд эрчим хүчний болоод техник тоног төхөөрөмж, шугам сүлжээнд осол гэмтэл гарсан

2.7.7. Байгалийн гамшиг тохиолдсон

2.8. Мэргэжлийн байгууллагын эрх бүхий ажилтан ажил үүргийн шаардлагаар хэрэглэгчийн сан-техникийн тоног төхөөрөмжинд үзлэг шалгалт хийх зорилгоор ажлын байранд нэвтрэх эрхтэй.

2.9. Хэрэглэгчийн шугам сүлжээний холболт угсралтын зөрчлийг арилгуулах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, хэрэглэгч хүсэлтээ гаргаж зардлаа төлсөн тохиолдолд засвар үйлчилгээ хийх эрхтэй.

2.10. Өөрийн өмчлөлд байгаа ннженерийн барилга, байгууламж, шугам сүлжээнд технологийн шаардлагын дагуу засвар үйлчилгээ, шинэчлэлтийг хийнэ.

Гурав. Хэрэглэгчийн эрх, үүрэг

3.1. Хэрэглэгч нь энэхүү гэрээний 1.1-д заасан хууль дүрмүүд болон бусад холбогдох хууль журмын актуудад заагдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2 Хэрэглэгч нь стандартын шаардлага хангасан усаар хангуулах, хэрэглээнээс гарсан бохир усаа хангагчийн шугам сүлжээнд нийлүүлэх эрхтэй.

3.3. Хэрэглэгч нь ус хэрэглэж, бохир ус татан зайлуулсны төлбөрөө сар бүрийн 25-ны дотор төлнө.

3.4. Хэрэглэгч хангагчийн зөвшөөрөлгүй шугам сүлжээний холболтыг өөрчлөх эрхгүй.

3.5. Хангагч гэрээнд заасан шаардлага хангагсан усаар хангаж, бохир ус татан зайлуулагүй тохиолдолд төлбөрийг хасч тооцох эрхтэй.

3.6 . Хангагчийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжинд гарсан гэмтлийг хангагчид яаралтай мэдэгдэж засварлуулна.

3.7. Хэрэглэгч өөрийн өмчлөлийн шугам сүлжээ тоолуурын бүрэн бүтэн байдлыг хангаж засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг цаг тухайд нь хийлгэнэ. Үйлчилгээ хийгээгүйгээс үүдэн гарах хохирлыг хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.

3.8. Хэрэглэгч нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан шугам сүлжээний харьяаллын дагуу өөрийн эзэмшилд байгаа шугам сүлжээ, тоног төхөөрөмжиндөө засвар үйлчилгээ хийж хэвийн ажиллагааг хангах.

3.9. Барилга объектоо бусдад шилжүүлэх, худалдах тохиолдолд хангагчид мэдэгдэн шинэ эзэмшигчийн төлөөлөлтэй хамт усны тоолуурын заалтыг авч сүүлчийн тооцоог хийх ба шинэ хэрэглэгчтэй гэрээ байгуулах нөхцлийг бүрдүүлж өгөх

3.10. Тоолуурын ажиллагаа, усны хэрэглээгээ тогтмол хянаж усны зүй бус алдагдал гаргахгүй байх

Дөрөв.Төлбөр тооцоо

4.1. Хангагч, хэрэглэгч талууд нь ус хэрэглэсний болоод бохир ус татан зайлуулсны төлбөр тооцоо үйчилгээний хөлсийг ЭХЗЗөвлөл, Усны зохицуулах зөвлөл, аймаг, сумын ИТХ-ын тогтоол зэрэг эрх бүхий байгууллагаас тогтоосон /хавсралтанд заасан/ үнэ тарифийг мөрдлөг болгон тооцоог хийнэ

4.2. Үнэ тариф өөрчлөгдвөл эрх бүхий байгууллагуудын тогтоол шийдвэрт заасан хугацаанаас эхлэн мөрдөх ба шийдвэрийг хэрэглэгчид 30 хоногийн өмнө мэдэгдэнэ.

4.3. Үнэ нэмэгдсэнээс хойш 10 хоногийн дотор хэрэглэгч хангагч дээр ирж тооцоогоо дуусгаж гэрээнд өөрчлөлт оруулах ба энэ хугацаанд өөрчлөлт хийгээгүй нь шинэ үнэ мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.

4.4. Хэрэглэгч нь гэрээнд заасан хугацаанд хэрэглэсэн ус, дулааны төлбөр тооцоогоо хийгээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй үнийн дүнгийн 0.5 хувийн алданги тооцно.

4.5. Цэвэр бохир ус болон бусад үйлчилгээний төлбөрийг 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй тохиолдолд хэрэглээг хязгаарлах ба 10 хоногийн дотор зөрчлийг арилгаагүй бол хууль хяналтын байгууллагад мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

4.6. Усны, тоолуур нь зогссон, эвдэрсэн хугацааг хангагчид мэдэгдээгүй тохиолдолд хамгийн сүүлчийн тооцоо хийсэн хугацаанаас хойш задгайгаар хэрэглээнд тооцож тоолуур хэвийн ажиллагаатай байх үеийн дундажаар бодож тооцоо хийнэ.

4.7. Хэрэглэгч нь цэвэр ус түгээгүүр, ариутгах татуургад дур мэдэн холболт хийсэн, усны тоолуур баталгаагүй буюу эвдэрсэн, хяналтын битүүмжлэл задалсан, тоолуурын хэвийн ажиллагааг алдагдуулсан нь тогтоогдвоя хэрэглэсэн усны хэмжээг тогтоохдоо ус түгээгүүрийн оролтын яндан хоолойн хөндлөн огтлолоор хоногт усыг 1,5м/секундын хурдтайгаар нэвтэрч байснаар тооцож үнийг нөхөн төлүүлнэ.

Тав. Харилцан хүлээх харилцаа

5.1. Гэрээтэй холбогдон гарах аливаа - асуудлыг хоёр тал хамтран шийдвэрлэх ба харилцан тохиролцоонд хүрээгүй тохиолдолд асуудлыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

5.2. Энэ гэрээнд заагдаагүй .бусад асуудлыг гэрээг батлах үед мөрдөгдөж байсан Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу зохицуулна.

5.3. Хэрэглэгч нь үндэслэлгүй шалтгаанаар хангагчтай гэрээ байгуулаагүй нь хэрэглэсэн ус, зайлуулсан бохир усны төлбөрөө төлөхгүй байх үндэслэл болохгүй.

5.4. Усны тоолуурын ажиллагаатай холбоотой маргааныг МХГазар, СХЗүйн төвийн улсын шалгагч, байцаагчийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

5.5.Хэрэглэгч нь усны тоолуурыг санаатайгаар зогсоосон нь тогтоогдвол Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн дагуу арга хэмжээ авна.

5.6.Гэрээнд гарын үсэг зурж тэмдэг дарж харилцан баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж мөрдөгдөх ба гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Гэрээний хавсралт № 01

№	Үйлчилгээний төрөл	Ангилал	Хэмжих нэгж	Үндэслэл	Нэгж үнэ /НӨАТ-гүй/
1	Цэвэр ус	Төвлөрсөн шугаманд холбогдсон	төг/л	Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2017 оны 6-р сарын 30-ны өдрийн 80 дугаар тогтоол	4 төг 20мөнгө
2		Зөөврөөр	төг/л		6 төг 50 мөнгө
3	Бохир ус	Төвлөрсөн шугаманд холбогдсон	төг/м3		3 төг 40 мөнгө
4		Зөөврөөр	төг/хүн		6 төг

Хавсралт № 02

№	Оролтын шугамын голч /мм /	Суурь хураамж НӨАТ-гүй/
1	15	3600
2	20	4960
3	25	7600
4	32	11200
5	40	16720
6	50	25680
7	65	32640
8	80	44240
9	100	65600
10	150	104400
11	400-аас дээш	384000

Гэрээ байгуулсан:

Хангагчийг төлөөлж:

Дундговь-Ус ОМОНТ

Н.И. Дорж

70593684-УТАС

Хэрэглэгчийг төлөөлж:

Г.ХБХБ Төгрөг

Н.И. Дорж

